

Зохиогчид

1. **Д.Цэрэнпил**. МУИС-ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн багш, тэргүүлэх профессор. Санхүүгийн онол, практикийн асуудал, төсвийн орлого зарлагын бүтэц, бүрэлдэхүүн, зах зээлд шилжих үеийн санхүү мөнгөний бодлого, үндэсний бүтээгдэхүүн, үндэсний баялагийн тухай асуудлаар голлон судалгааны ажил хийдэг.

2. **Д.Давгдорж**. Доктор (Sc), профессор. МУИС-ЭЗС-ийн багш, Монголын Маркетингийн Холбооны ерөнхийлөгч. Судалгааны чиглэл: Маркетингийн онол, практик, эдийн засаг, бизнесийн хөгжил, тогтвортой хөгжлийн асуудлууд. Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээл: "Маркетингийн судалгаа" УБ, 2007, "Монгол улс зах зээлд", УБ, 2007

3. **Х.Цэвэлмаа**. МУИС-ЭЗС-ийн Эдийн засгийн онолын тэнхмийн багш, доктор PhD, Эдийн засгийн бодлого судлал нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, хөгжлийн асуудлууд, хэрэглэгчийн ба өрхийн үйл хөдлөл, хүмүүсийн хэрэглээ ба институцийн өөрчлөлтөөр судалгааны ажил хийдэг.

4. **Д.Чимгээ**. МУИС-ЭЗС-ийн Математик-Компьютерийн тэнхмийн багш, доктор PhD. Судалгааны чиглэл: Менежмент, Маркетинг-ийн мэдээллийн систем, компьютерийн бүртгэл, аудит. Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээл "Хөрөнгө оруулалтын шинжилгээг Ехсел дээр гүйцэтгэх нь", "Төслийн шинжилгээ ба Microsoft projekt" УБ, 2006, Монгол улс зах зээлд" УБ, 2007.

5. **Б.Энх-Амгалан**. МУИС-ЭЗС-ийн Статистикийн тэнхмийн багш, доктор PhD, Судалгааны чиглэл "Үндэсний тооцооны системийн асуудлууд, Эдийн засгийн өсөлт, Бүтээл Empirical analysis of Economic growth: The case of Mongolia" AJIA KEIZAI Vol 48, No 10, pp2-24

6. **Б.Болор**. МУИС-ЭЗС-ийн Менежментийн тэнхмийн эрхлэгч, Доктор /Ph/. Судалгааны чиглэл: "Хөдөлмөрийн зах, зээл хүний нөөцийн асуудал"

7. **Л.Мөнх-Очир**. МУИС-ЭЗС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхмийн багш дэд профессор, докторант. Судалгааны сэдэв: Аудитын удирдлага, үнэлгээ, хөрөнгө оруулалтын төслийн шинжилгээ.

8. **Л.Наранчимэг**. МУИС-ЭЗС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхмийн багш, докторант, судалгааны сэдэв: "Удирдлагын шийдвэр гаргалтад санхүүгийн тайланг ашиглах нь"

9. **Р.Бадамханд**. МУИС-ЭЗС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхмийн багш, докторант, судалгааны сэдэв: "Олзворлох салбарын нягтлан бодох бүртгэлийг боловсронгуй болгох асуудал"

10. **Д.Нямаа**. МУИС-ЭЗС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхмийн багш, докторант, судалгааны сэдэв: "Нэгтгэсэн санхүүгийн тайлагналын онол арга зүйн тулгамдсан асуудал"

11. **Г.Мөнхнасан**. Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн багш. Мөнжи Их Сургуулийн докторант (Өмнөд Солонгос), эдийн засгийн бодлогын асуудлаар судалгаа хийж байгаа.

12. **Б.Дэмид**. Доктор PhD, дэд профессор. Судалгааны чиглэл: Боловсрол судлал, бүс нутаг судлал. Хэвлүүлсэн бүтээл "Дээд боловсролын шинэчлэлийн зарим асуудал" 2007 он, УБ "Баруун бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөв байдал" 2007 он, УБ

13. **Ж.Уянга**. МУИС-ЭЗС-ийн багш магистр. Судалгааны сэдэв: Хөрөнгө оруулалт төслийн шинжилгээ, Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн шинжилгээ, Хөгжлийн эдийн засаг. Сүүлийн жилд хэвлүүлсэн бүтээл: Nexus Between Financial Sector Development and Economic Growth: Empirical analysis of 112 countries, Journal of Graduate School of International Cooperation Studies, Volume coming March, 2008, Japan,

14. **Ц.Баярмаа**. МУИС-ЭЗС-ийн Анли хэлний тэнхмийн багш, магистр. Судалгааны чиглэл: Харьцуулсан хэл шинжлэл. Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээл: "Англи хэлний дасгалууд", 2005, УБ, "Англи хэлний сонсох дасгалууд", 2005, УБ. "Эдийн засаг, онол практик" 2005 №241/13.

15. **Д.Долгорсүрэн**. МУИС-ЭЗС-ийн Анли хэлний тэнхмийн багш, магистрант, Судалгааны сэдэв "Харьцуулсан хэл шинжлэл"

15. **Б.Нарантуяа**. МУИС-ЭЗС-ийн докторант. Судалгааны ажил: "Монгол орны зар сурталчилгааны менежментийг боловсронгуй болгох нь"

1

УЛСЫН ТӨСӨВ-ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Д.Цэрэнпил

1. Төрийн санхүүгийн бодлогын шинэчлэл зайлшгүй

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжихэд цаг үе, орчин нөхцөлд зохицсон санхүүгийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх нь нэн тэргүүний зорилт байв.

Санхүүгийн бодлого нь төрийн үүрэг, эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар тавьж байгаа программ зорилтыг хэрэгжүүлэхэд зориулан санхүүгийн нөөцийг дайчлах, хуваарилах, ашиглахад чиглүүлэн авч явуулах арга хэмжээг бүхэлд нь тусгаж байгаа юм. Цаг үе орчин нөхцөлтэйгээ уялдаж төрийн санхүүгийн бодлого мөчлөгийн онцлогтойгоор хэрэгжиж ирлээ.

Өнгөрсөн арван долоон жилийн хугацаанд манай орны санхүү, мөнгө зээлийн тогтолцоо 1991-1994 онд гүнзгий хямралд орж, 1995-1997 онд сэргэж, 1997-1999 онд дахин хямарсан бол 2000 оноос тогтворжиж, чадваржих үе шатанд оров.

Эдийн засгийн хямралын үед сэргэлтийн болон тогтворжилтийн үед явуулах санхүүгийн бодлого, түүний арга механизм нь өвөрмөц шинжтэй байлаа.

Төрийн санхүүгийн бодлого нь дотроо төсвийн, татварын, мөнгө-зээлийн, хөрөнгө оруулалтын болон нийгмийн бодлого, түүнчлэн улс хоорондын санхүүгийн асуудлыг хамарсан тодорхой чиглэлтэйгээр цогцолбор байдлаар явагдаж байна.

Манай орны санхүүгийн бодлогод нэн тэргүүнд:

- Эдийн засаг, нийгмийн тогтвортой байдал, давшингуй өсөлтийг хангахад санхүүгийн орчин нөхцлийг бүрдүүлэх;
- Нийгмийн хурц, тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, төвөгтэй байдлыг бууруулах;

- Улсын санхүүг эрүүлжүүлж, чадваржуулан эдийн засгийн макро, микро түвшинд санхүүгийн тэнцвэржилт, балансжилтыг хангах;
- Мөнгө-зээлийн тогтолцоог улам боловсронгуй болгож, хэвийн чадварлаг үйл ажиллагааг явуулж, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүргийг нь эрс дээшлүүлэх;
- Таваарын ба мөнгөн урсгалын балансжилтыг хангаж сайжруулах;
- Аж ахуйн бүх нэгж, бүс нутаг, аймаг, орон нутагт санхүү-эдийн засгийн биеэ даасан байдал, хариуцлагыг өндөржүүлэх, төсөв-татварын хүрээнд ижил нөхцлийг бүрдүүлэх;
- Бүхий л салбар, субъектүүдэд хөрөнгийн ашиглалтын үр ашгийг сайжруулах, санхүүгийн сахилгыг бэхжүүлэх асуудал тулгамдсан зорилт болж байна.

Шилжилтийн үеийн санхүүгийн бодлого, түүний улс төрийн удирдлага нь тухайн нөхцөл байдлаас үүдэн гурван үндсэн асуудлыг өөртөө агуулж байдаг. Үүнд:

Нэгд: Манай орны эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой үе шатанд тавигдаж байгаа зорилтод хүрэхийн тулд зайлшгүй шийдвэрлэх санхүүгийн хэтийн ба ойрын бодлогын гол зорилгыг тодорхойлж хэрэгжүүлэх.

Хоёрт: Санхүүгийн бодлогын ойрын ба хэтийн зорилтыг оновчтой шийдвэрлэхийн тулд санхүүгийн зохион байгуулалтын тодорхой хэлбэр, арга хэрэгслийг боловсруулж зохистой хэрэглэх.

Гуравт: Тавьсан зорилтыг шийдвэрлэх, түүний хэрэгжилтийг зохион байгуулах, шинэ цагийн чадвартай, мэдлэгтэй боловсон хүчнийг бэлтгэж, сонгон оновчтой байршуулах явдал юм.

Санхүүгийн бодлого, удирдлага нь хүндрэл бэрхшээлтэй байнга тулгарч, төвөгтэй асуудлыг шийдвэрлэх үйл явцаар өрнөж байна. Шилжилтийн эхэн үед санхүүг зах зээлийн ёс жаягт оруулах анхны алхам хийгдэж эхэлсэн боловч эдийн засгийн хямрал, уналтын үр дагавараар хөрөнгө мөнгөний хомсдолд орж хүнд байдалд байснаа ерээд оны дунд үед сэргэж инфляцийн түвшин болон төсвийн алдагдал буурч, урсгал тэнцэл ашигтай гарч, зохих хэмжээний нөөц бүрдэж эхэлсэн. Энэ нааштай хандлага удаан хадгалагдаж чадаагүй.

1997–1999 оны үед гааль, татварын тогтолцоог гажуудуулж, санхүүгийн мэргэжлийн удирдлага алдагдсанаас төсвийн алдагдал ДНБ-нд 12.5%-ийг эзлэх болж урсгал төсөв ч алдагдалд орсон. Цалин, тэтгэвэр, нийгмийн арга хэмжээг зээл авч, өр тавьж санхүүжүүлэхэд хүрч санхүү, төсөв хямралд эргэн орсон.

Төсөв, санхүүгийн тогтолцооны дээрх гажуудлын улмаас хувийн хэвшил, төрийн өмчийн болон төсөвт байгууллагуудын хооронд өрийн сүлжээ үүсч, олон арван тэрбум төгрөгийн төсвийн санхүүжилт хүлээгдэн хуримтлагдаж,

далд эдийн засгийн хүрээ өргөжиж, хээл хахууль, авилгал дэлгэрч, гадаад талаас санхүүгийн дэмжлэг авах итгэл алдагдсан, төсөв, санхүүгийн сүйрэл нүүрлэсэн байв. Иймээс 2000 оноос төрийн санхүүгийн бодлого, удирдлагыг боловсронгуй болгох талаар шийдвэртэй арга хэмжээг авч эхэлсэн юм. Энэ хүрээнд “ Улсын төсөв-санхүүгийн тогтолцоог эрүүлжүүлэх ” томоохон зорилт дэвшүүлэн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, гадаад дотоод өр авлагын дарамтнаас ангижрах, улсын төсвийн удирдлагыг сайжруулахын тулд төсвийн орлогын эх үүсвэрийг тогтвортой нэмэгдүүлэх, төсвийг дунд хугацааны ба хэтийн макро эдийн засгийн бодлоготой уялдуулан төлөвлөж, санхүүжилтийг боловсронгуй болгох, үйл ажиллагааны үр дүнг санхүүжүүлэх тогтолцоонд шилжих, төсвийн зарлагын удирдлага, санхүүжилтийн норм, стандартын үндэслэлийг сайжруулах зэрэг тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв.

Төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах зорилгоор төсвийн санхүүжилтэд нормативын аргыг нэвтрүүлж, жилийн төсөвлөлтөөс дунд хугацааны тасралтгүй төсөвлөлтийн аргад шилжив. Улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв хоорондын харилцааг боловсронгуй болгохын тулд төсвийн харилцааны олон улсын жишгийн дагуу төсөв хоорондын тэнцвэржүүлэлтийн орлого хуваарилах шинэ аргад 2002 оноос шилжсэн.

Санхүүгийн бодлогын шинэчлэл нь орлого, зарлагын удирдлага, татвар, гаалийн бодлогын шинэчлэл, өөрчлөлттэй салшгүй холбоотой билээ. Сүүлийн жилүүдэд хийгдсэн татварын шинэчлэл нь татварын ачааллыг хөнгөвчлөх, төсвийн зардлын өсөлтөөс шууд хамаарсан татварын бодлогоос аль болох зайлсхийх, татвар тэгш, шударга байх, татварын бааз суурийг өргөтгөх, хуулийн хэрэгжилтийг чангатгах, татвар нь эдийн засгийн өсөлтийг урамшуулагч, гадаад дотоод хөрөнгө оруулалтыг идэвхижүүлэх, үйлдвэр эрхлэгчдийг төрөөс дэмжих хөшүүрэг байх зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна. Ялангуяа 2007 оноос мөрдөж эхэлсэн шинэчлэл нь нийт татварын хувь хэмжээг бууруулсан бөгөөд цаашид татварын ачааллыг үе шаттай бууруулах, ялангуяа том татвар төлөгчдөд хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх, зах зээлийн нийтлэг жишгийн дагуу цаашдаа татварын нэг шатлалт тогтолцоонд шилжих алхмыг хэрэгжүүлэх зорилтыг агуулж байна.

2003 оноос төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийг бүрэн агуулгаар нь хэрэгжүүлж эхэлснээр Монгол Улсын төсвийн харилцаа үндсээрээ өөрчлөгдлөө. Төсвийн удирдлагын шинэчлэл нь төрийн албаны бүтэц, зохион байгуулалт, зардлын менежмент, нийгмийн салбарын өөрчлөн байгуулалтын хэрэгжилт, үр дүнг агуулж байгаа юм. Засгийн газар Дэлхийн банктай хамтран Монгол Улсын төсвийн зардлын удирдлагыг

сайжруулах, төрийн албыг шинэчлэх дунд хугацааны стратеги, хөтөлбөрийг нарийвчлан боловсруулж, одоо хэрэгжүүлж байна.

Төрийн сангийн тогтолцоог төгөлдөржүүлэн төрийн сан хөмрөгийг арвижуулахад чиглүүлэн төсөв, төрийн сангийн шинэчлэлийг хийж байна.

Төрийн сангийн тогтолцоог нэвтрүүлснээр төсөв хууль гэдэг утгаараа хэрэгжих механизм бүрдэж, Засгийн газрын мөнгөн хөрөнгийн удирдлага сайжирч, төлбөр гүйцэтгэх хариуцлага дээшилж, төсвийн бүртгэл, мэдээ тайлан цаг хугацаандаа гардаг болж, төсвийн урсгал хяналт сайжирч, төсвийн сахилга бат дээшилж, зөрчил дутагдал сүүлийн жилд эрс буурч байна. Төрийн сангийн тогтолцоог бий болгохдоо орчин үеийн тэргүүний технологи, техник, программ хангамжид суурилсан, электрон сүлжээгээр төлбөр тооцоогоо дамжуулан гүйцэтгэдэг болох зорилтыг хамтад нь хэрэгжүүлж байна.

Одоогийн байдлаар манай орны эдийн засгийн өсөлтийн хурд нэмэгдэж байгаа боловч түүний хэмжээ, бүтэц ихээхэн доогуур түвшинд байна. Өнөөдөр эдийн засгийн эрчимтэй хөгжил, чанарын өсөлтийг хангахад нөлөөлөх механизм хэрэгтэй. Энэ механизмд төрийн санхүү төсөв гол үүрэгтэй. Механизм нь ДНБ-ийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амын амьдралын чанар, аж байдлыг дээшлүүлэх, ядуурлын хэмжээг эрс бууруулах зорилтыг шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлнэ.

2. Улсын төсөв-эдийн засгийн хөгжлийн нэн чухал хэрэгсэл

Санхүүгийн бодлого юуны урьд төсвийн тогтолцоогоор дамжин хэрэгжинэ. Эдийн засгийг төрөөс үр ашигтай зохицуулахад гол асуудлын нэг бол төсөв, татварын, мөнгө зээлийн бодлогын хоорондын харилцан уялдааг сайжруулах шаардлагатай байв. Төсөв татварын бодлого тэнцвэржүүлэгч, хуваарилагч, хянагч үүрэгтэй. Монгол улсын төсөв нь эдийн засгийн бодлогын нэгтгэсэн илэрхийлэл болдог. Төсөв, татвар ДНБ-ийг дахин хуваарилах хамгийн зохистой арга болж ашиглагддагаараа эдийн засгийн макро, микро түвшинд зохистой тэнцвэрийг хангах, улс орны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, төр засгийн программын санхүүгийн бааз нь болоход чиглэгдэж байна. Төсөв, татварын бодлогоор дамжуулан үйлдвэрлэл, хэрэглээний эрэлтийг зохицуулж урамшуулан, улмаар нийт эдийн засгийн тогтворжилт, өсөлтөд нөлөөлөх болсон. Аж ахуйн бүх субъектийн санхүүгийн байдал, тэдний хуримтлал, мөнгөн хөрөнгийн хуваарилалтанд мөн идэвхитэй шууд ба дам нөлөө үзүүлж ирлээ. Зах зээлийн эдийн засагт шилжих стратегийн зорилт болон төр улс орны эдийн засаг нийгмийн үйл явцийг зохион байгуулах талаар өөрийн үүргээ хэрэгжүүлэхэд зориулж дотоодын нийт бүтээгдэхүүн, үндэсний баялгийн хэсгийг хуваарилах замаар төрийн гарт төвлөрсөн хөрөнгийн санг бүрдүүлэх, ашиглахтай холбоотой гарч байгаа мөнгөн харилцааг төсөв илэрхийлж байна.

Монгол улсын төсвийн орлого, зарлагын хэмжээ өсөж, дотоод бүтцийн хувьд эерэгээр өөрчлөгдөж байна.

Хүснэгт 1.

Монгол улсын төсөв / 1991-1999 оноор, тэрбум төг/

Үзүүлэлт	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999
Нийт орлого	6.5	11.9	54.8	85.4	140.9	159.9	212	225.5	254.8
Нийт зарлага	8.7	12	61.6	98.9	149.3	176.5	287.6	342.2	361.7
Төсвийн тэнцэл	Урсгал -1.5	-0.1	10.3	7.6	34.2	26.2	13.4	-5.6	56.2
ДНБ-д эзлэх хувь	Нийт -2.2	-0.1	-6.8	-13.5	-8.4	-16.6	-75.6	-116.7	-106.9
	Нийт орлого 32.1	23.9	33.0	30.4	33.8	30.6	29.2	27.4	27.9
	Нийт зарлага 47.2	28.7	37.1	35.8	34.9	33.1	38.4	39.1	36.2
	Нийт алдагдал -15.1	-4.8	-4.1	-4.2	-1.5	-2.5	-9.1	-14.3	-11.6

Дээрх байдлаас үзэхэд:

- МУ-н төсвийн орлого, зарлагад инфляцын нөлөөлөл байгаа боловч эдийн засгийн сэргэлтийг дагаж өөрийн сууриар өсч байна. 1999 оныг 1996 онтой харьцуулахад төсвийн орлого 1.6 дахин, зарлага 2.1 дахин өссөн байна. Гэхдээ зарлагын өсөлт нь орлогынхоосоо түргэн байлаа. Энэ нь төсвийн алдагдал өсөх нөхцлийг бүрдүүлж байгаа сөрөг үзэгдэл байв.
- Төсвийн орлого, зарлагын бүрдүүлэлтээр дамжин, эдийн засаг, нийгмийн хүрээнд төсвийн зохицуулалтын үүрэг хангагдах ёстой. Гэтэл тийм хүчтэй зохицуулагч болох чанараа бүрэн харуулж чадах хараахан болоогүй ч тийм хандлага ажиглагдаж байна.
- Төвлөрсөн төлөвлөлтийн үед үндэсний орлогын 60 гаруй хувийг төсөвт төвлөрүүлэн хувиарлаж байсан бол 1999 оны байдлаар ДНБ-нд төсвийн орлого 27.9, зарлага нь 36.1 хувийг эзлэх болсон нь зах зээл хөгжсөн орнуудын дундаж төвшинд байлаа. Энэ нь санхүүгийн секторт ардчилалын үйл явц өргөжсөнийг харуулах боловч үнэн чанартаа орлого нь үндэсний үйлдвэрлэлийн уналтыг илэрхийлнэ.
- Төсвийн нийт алдагдал туйлын ба харьцангуй дүнгээрээ өсөж 1999 онд 106.9 тэрбум төгрөгт хүрсэн нь 1996 оныхоос 6.4 дахин өсчээ. Түүнийг нөхөх эх үүсвэрт дотоодын зээл ба гадаадын зээл тусламж зонхилох үүрэг гүйцэтгэдэг боллоо. Энэ нь гадаадын зээлийн өрийг улам нэмэгдүүлж байгаа юм.

Төсвийн орлого зарлагын өсөлт, бууралт, бүтцийн өөрчлөлт нь улсын эдийн засаг, нийгмийн хөгжил, өөрчлөлтийг тодорхойлж байдаг. 1991-1999 онд төсвийн орлого зарлага нийт дүнгээрээ өсөж, бүтцийн хувьд өөрчлөгдлөө. Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлого, хөрөнгийн орлого, гадаадын зээл тусламжийн орлого гэсэн эх үүсвэрээс бүрдэж байна.

1999 оны байдлаар төсвийн нийт орлогын дүнд татварын орлого 71.1 хувь, татварын бус орлого нь 26.1 хувь, хөрөнгийн орлого 0 хувь, бусдыг гадаадын тусламжийн орлого тус тус эзлэх болов. Санхүүгийн бодлогын чухал хэсэг бол төсвийн орлогын, түүний дотор албан татварын үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх явдал юм.

Татварын бодлогыг боловсруулахад нийтлэг онол, хандлагыг баримтлахын зэрэгцээ, монгол орны аж ахуйн бүтэц, тэдний татвар төлөх чадамж, хүн амын мөнгөн орлогын түвшний өвөрмөц байдлыг бодитойгоор харгалзах ёстой байв.

1992 онд батлагдсан татварын цогцолбор хуулиуд түүний дараагаар оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг хийхэд энэ чиглэлийг баримтлав.

Шилжилтийн өнөөгийн нөхцөлд татварын бодлогыг боловсруулахад нэгд, төр, аж ахуйн нэгжийн хооронд нөөц хуваарилалтын хамгийн оносон харилцааг тогтоох, хоёрт, санхүүгийн нөөцийн өсөн нэмэгдэж байгаа эрэлтийг дагаж төсвийн орлогын баазыг бэхжүүлэх үүднээс орлогыг зохистой хэмжээгээр дайчлах явдлыг баримжаалах, гурв, өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр аж ахуйн бүх нэгжид эдийн засгийн хувьд бие дааж өөрийгөө санхүүжүүлж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, дөрөвт, үйлдвэрлэл, хэрэглээг урамшуулах, хувийн хэвшил, жижиг үйлдвэрлэлийг дэмжих, тав, хүн амын орлогын ялгааг зохицуулах, ядуу, эмзэг хэсгийн амьдралын баталгааг бүрдүүлэх үзэл баримтлалаар хандсан болно.

Татварын тогтолцооны эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь түүний төрөл, бүтцээс олон талаар хамаарна. Одоо 10 төрлийн татвар, 8 төрлийн хураамж хэрэглэгдэж байна.

Монгол улсын төсөвт орж байгаа албан татвар нь шууд ба шууд бус татвар гэсэн хоёр төрөлд хуваагдана. Шууд татвар нь аж ахуй нэгжийн орлогын албан татвараас бүрдэнэ.

Хүснэгт 2.

Татварын орлогын бүтэц

	1995	1996	1997	1998	1999
Татварын нийт орлого. Үүнээс:	100	100	100	100	100
Орлогын албан татвар	46	37.7	38.2	33.3	21.5
Нийгмийн даатгалын шимтгэл	15	15.3	12.9	17	16.4
Худалдааны албан татвар буюу НӨАТ	15.5	17.8	23.2	27.9	33
Онцгой албан татвар	8.2	9.2	12.4	16.8	14.7
Тусгай үйлчилгээний албан татвар	3.1	4.3	2.9	3.9	3.7
Гаалийн албан татвар	9.0	11.5	7.3	1	4.9
Бусад албан татвар	3.2	4.2	3.1	5.1	5.1

Эх сурвалж: "Монгол улс зах зээлд" статистикийн эмхтгэл, (1989-2002).
-УБ, 2004. 120 дахь талд байгаа тоо баримтыг ашиглав.

1997 оныг хүртэл төсвийн нийт орлогын 70% гаруй нь татварын орлогоос бүрдэж байсан бол, 1998 онд 64.2% болж буурлаа. Харин 1999 онд өссөн. Ер нь сүүлийн жилүүдээс үзэхэд төсвийн орлогод татварын нийт орлогын болон орлогын албан татварын эзлэх хувь жил дараалан буурсан байна. Энэ нь тухайн жилүүдийн эдийн засгийн байдал, зах зээлийн төлөвшил, төсөв, татварын хуулийн боловсруулалт болон санхүүгийн үйл ажиллагааны зохион байгуулалтаас шалтгаалж байв.

Төсвийн бодлого зохицуулалт нь түүний зарлага, төрийн сангийн бодлоготой салшгүй холбоотой. Зах зээлийн эдийн засагт шилжиж төлөвшүүлэх программ, концепци, төр засгаас улс орны эдийн засаг, нийгмийг удирдан зохицуулах, бүх нийтийн амин чухал эрх ашиг, аюулгүй байдлыг хамгаалах талаар өөрийн үүргээ хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай санхүүгийн нөөцийг бүрдүүлэх, ашиглах гол арга хэрэгсэл бол төсвийн зарлагын бодлого байлаа. Төсвийн зарлага нь нэг талаас Монгол орны өнөөгийн нөхцөлд орлогын хязгаарлагдмал боломж, нөгөө талаас, эдийн засаг, нийгмийн хямралаас гарах, цаашдын тогтвортой хөгжлийг хангахад санхүүгийн нөөцийн эрэлт, хэрэгцээний шаардлагаас шалтгаална.

Эдийн засгийн суурь дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх, хүний хөгжлийн гол асуудал, боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, эрүүл мэнд, хүн амын амьдралын нийгмийн баталгаа хангамжийг бүрдүүлэх, улс орны батлан хамгаалах, төр засгийн удирдлагын үйл ажиллагаа болон бусад нэн шаардлагатай арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхэд төсвийн зарлага зориулагдана. Урсгал зарлага нь 1999 оны байдлаар төсвийн нийт зарлагын 68.5%-г, хөрөнгийн зардлын 7.8%, гадаад, дотоод зээлийн төлбөр 23.6%, тус

тус эзэлж байв. Хөрөнгийн зардал, гадаад зээлийн төлбөр нь цаашдаа өсөх хандлагатай байлаа. Зах зээлийн эдийн засаг нийгмийн бүтэц, төр засгаас тавьж буй бодлого, арга хэмжээний дагуу төсвийн зарлагын зориулалтын ангилал нэлээд өөрчлөгдлөө.

Хүснэгт 3.

Төсвийн зарлагын зориулалтын бүтэц /1991-1999 он, хувиар/

	1991	1995	1999
Нийт зарлага	100	100	100
Үүнээс: Нийтийн ерөнхий үйлчилгээ	6.3	8.9	9.1
Боловсролын үйл ажиллагаа	24.2	16.4	17.9
Эрүүл мэндийн үйл ажиллагаа	11.6	11.1	9.9
Нийгмийн даатгал, халамж	12.1	16.3	16.6
Орон сууц, нийт аж ахуй	2.6	1.6	1.3
Амралт спорт, соёл урлаг	4.6	3.5	3.2
Эрчим хүч, дулаан хангамж	4.9	8.6	1.3
ХАА ойн аж ахуй	2.9	2.9	1.4
Эрдэс баялаг, уул уурхайн үйлдвэр, барилга	6.2	1.9	0.3
Тээвэр холбоо	4.7	3.0	1.9
Бусад	1.1	2.5	1.2

Эх сурвалж: “Монгол улс зах зээлд” статистикийн эмхтгэл.
(1989-2002) –УБ, 2004, 121 дэх тал.

Шилжилтийн жилүүдэд төсвийн зарлагын зориулалт үндсээрээ өөрчлөгдлөө. Нэгэнт төрийн өмч хувьчлагдаж үйлдвэрлэлийн салбарууд бараг бүхэлдээ шахам хувийн өмчинд шилжсэн нөхцөлд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж зах зээл дээр борлуулалтын үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө аж ахуйн нэгжүүдийг өмчийн харьяалал харгалзахгүйгээр том, жижиг гэж ялгахгүйгээр орлогоороо зарлагаа нөхөж ашигтай ажиллах орчин, нөхцлийг нь бүрдүүлэх явдал гол үүрэг болж тавигдав.

Төсөв санхүүгийн бодлогын нэг гол хэсэг нь төсвийн зарлагын зориулалтыг оновчтой болгох, хүний хөгжлийн асуудлыг илүүтэй анхаарч боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хангамж, халамжийн зардлыг нэмэгдүүлэх, үр ашигтай хуваарилах чиглэлийг баримталж байна.

Харин 1996-1999 онд төсвийн зарлага нь орлогоосоо илүү хурдацтай өсөж, ер нь эдийн засгийн микро макро түвшинд санхүүгийн ихээхэн хүндрэлтэй, нэг ёсондоо хямрал үргэлжилж байсан учир төсвийн алдагдал туйлын хэмжээгээр 100 гаруй тэрбум төгрөгт хүрч дотоодын нийт бүтээгдэхүүнд 14 хүртэл хувийг эзэлж байлаа. Энэ үед санхүүгийн салбар бэрхшээл төвөгтэй байлаа.

2000 оноос эхлэн манай орны эдийн засаг, нийгмийн хөгжилд эрс ахиц гарч, цаашдын тогтвортой өсөлтийн суурь бүрэлдэв. Төсвийн орлого зарлага нийт хэмжээгээр өсөж, бүтцийн дэвшилтэт өөрчлөлт гарч, санхүүгийн чадвар харьцангуй дээшилж байна.

Хүснэгт 4.

Төсвийн орлогын бүтэц, бүрэлдэхүүн /тэрбум төг, %/

	2000		2001		2002		2003	
	дүн	%	дүн	%	дүн	%	дүн	%
Нийт орлого ба тусламжийн дүн	351.1	100	439.3	100	477.0	100	535.8	100
Урсгал орлого	346.2	98.6	429.9	97.9	469.7	98.5	526.4	98.2
А.Албан татварын орлого	260.6	74.2	328.2	74.7	359.2	75.3	404.4	75.5
Орлогын албан татвар	62.8	17.9	64.5	14.7	72.4	15.2	81.8	15.3
Нийгмийн даатгалын шимтгэл	39.3	11.2	54.0	12.3	54.4	11.4	63.6	11.9
НӨАТ	76.2	21.7	104.2	23.7	118.7	24.9	121.7	22.7
Онцгой албан татвар	41.0	11.7	53.3	12.1	51.3	1.8	58.9	11.0
Тусгай үйлчилгээний албан татвар	7.1	2.0	8.9	2.0	8.6	1.8	9.7	1.8
Гаалийн татвар	22.3	6.4	27.0	6.1	24.6	5.2	32.7	6.1
Бусад татвар	11.6	3.3	14.6	3.3	25.8	5.4	31.5	5.9
Б.Татварын бус орлого	85.6	24.4	101.7	23.2	110.6	23.2	121.9	22.8
В.Хөрөнгийн орлого	0.9	0.02	1.6	0.03	0.4	0.09	0.8	0.1
Г.Гадаад тусламжийн орлого	4.8	1.4	9.2	2.1	6.8	1.4	8.7	1.6

	2004		2005		2006	
	дүн	%	дүн	%	дүн	%
Нийт орлого ба тусламжийн дүн	713.1	100	837.9	100	1209.8	100
Урсгал орлого	706.2	99.0	832.6	99.4	1204.2	99.5
А.Албан татварын орлого	583.1	81.8	692.2	82.6	984.7	81.4
Орлогын албан татвар	144.1	20.2	178.2	21.3	373.5	30.9
Нийгмийн даатгалын шимтгэл	82.1	11.5	95.6	11.4	104.4	8.6
НӨАТ	163.1	22.9	181.0	21.6	224.8	18.6
Онцгой албан татвар	70.3	10.0	79.0	9.4	93.9	7.8
Тусгай үйлчилгээний албан татвар	1.9	1.5	11.0	1.3	12.4	1.0
Гаалийн татвар	44.7	6.3	57.0	6.8	68.5	5.7
Бусад татвар	62.1	8.7	83.8	10.0	100.9	8.3

Б.Татварын бус орлого	123.2	17.3	140.4	16.8	219.5	18.1
В.Хөрөнгийн орлого	0.8	0.1	1.0	0.1	0.8	0.06
Г.Гадаад тусламжийн орлого	6.1	0.9	4.3	0.5	4.1	3.4

Эх сурвалж: "Монгол улс зах зээлд" статистикийн эмхтгэл. (1989-2002) –УБ, 2004, 120 дахь тал. Монгол улсын статистикийн эмхтгэл. 2005, -УБ, 2006, 144 дэх тал. Сангийн яамны мэдээ зэргийг үндэслэв.

2006 оныг 2000 онтой харьцуулбал нийт орлого 3.4 дахин, үүнээс татварын орлого 3.8 дахин өслөө. Харин татварын нэр төрлөөр үзвэл орлогын татвар 5.9, хэрэглээний татвар /НӨТ, онцгой татвар, гаалийн татвар/ 2.7 дахин өслөө. Энэ нь:

Нэгд: Орлогын суурь нэлээд өөрчлөгдсөн;

Хоёрт: Орлогын албан татвар илүү хурдацтай өссөн нь манай орны аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжин тэлж, борлуулалтын хэмжээ, ашиг орлого нэмэгдэж байгааг харуулна.

2000-2006 онд Монгол улсын санхүү, төсөв, мөнгө-зээлийн тогтолцоонд бодитой ахиц өөрчлөлт гарч, энэ сектор тогтворжиж, чадавхи нь дээшиллээ.

2004 онд ДНБ 10.6 хувиар огцом өссөн. Харин 2006 онд 8%, 2007 онд 8.6%-иар өсөх төлөвтэй байна.хш

Эдийн засгийн макро, микро түвшинд тэнцвэржилт ахицтай байдалд орж байна. Үүнд: дотоод, гадаад хүчин зүйлийн эерэг нөлөөлөл их юм. Санхүү, төсөв, мөнгө-зээлийн сектор эдийн засгийн хөгжлийн харилцан нөлөөлөл, эргэх холбоо сайжирч байна.

Татварын орлогын төлөвлөгөө сүүлийн жилүүдэд тогтмол давж биелэн төсвийн нийт орлогын 80-аас илүү хувийг эзлэх болж, түүний ноогдуулалт, хураалтын зохион байгуулалт сайжирч байна. Үүний нөгөө талаар түүний орлогын суурь өргөжиж татвар төлөх эдийн засгийн чадавхи нэмэгдэж байна.

Хүснэгт 5.

2000-2006 онд татварын орлогын бүтэц /хувиар/

	2000	2001	2002	2003	2004	2005	2006
Татварын нийт орлого Үүнээс:	100	100	100	100	100	100	100
Орлогын албан татвар	24,1	19,7	20,2	20,2	24,7	25,7	37,9
Нийгмийн даатгалын шимтгэл	15,1	16,4	15,1	15,7	14,1	13,8	10,6
НӨАТ	29,2	31,7	33	30,1	28	26,1	22,8
Онцгой албан татвар	15,7	16,2	14,3	14,6	12,1	11,4	9,5

Тусгай үйлчилгээний албан татвар	2,7	2,7	2,4	2,4	1,9	1,1	1,3
Гаалийн албан татвар	8,6	8,2	6,8	8,1	7,7	8,2	6,9
Бусад татвар	4,5	4,4	7,2	7,8	10,6	12,1	10,2

Эх сурвалж: Тухайн онуудын статистикийн тоо баримт, сангийн яамны мэдээг үндэслэн тооцов

Татварын орлогын бүтэц өөрчлөгдөж байна. Орлогын албан татвар хэдийгээр жил бүр нэмэгдэж байгаа боловч 2000-2003 онуудад нийт орлогод 20 орчим хувийг эзэлж буурах хандлагатай байлаа.

Харин 2004 оноос эхлэн хувийн жин нь нэмэгдэж 2006 онд бүр 37.9 хувийг эзлэх боллоо. Үүнд аж ахуйн нэгжүүдийн орлого өсөж байгаа орлогын татвар ноогдуулах шатлалын дээд хэмжээг /40% байсан 30% болгож/ бууруулсан нь зохих нөлөө үзүүлсэн. Мөн манай орны экспортын гол бүтээгдэхүүн зэс, алтны дэлхийн зах зээлийн үнэ сүүлийн жилүүдэд огцом өсөж, түүнээс орох орлого нэмэгдэж ирсэнтэй холбоотой.

Харин хэрэглээний татвар болох шууд бус татвар 60 гаруй хувийг эзэлж байсан бол 2006 онд 40.5%-ийг эзлэх боллоо. Эндээс үзэхэд манай төсөв хэрэглээний шууд бус татвар дээр суурилсан хэвээрээ байна. Энэ нь онол, практикийн үүднээс гүнзгий судлуудтай асуудал боллоо. Төсвийн зарлага хэмжээ ч өсөж, бүтцийн хувьд өөрчлөгдөж байна.

Хүснэгт 6.

Монгол улсын төсвийн зарлага /2000-2006 он, тэрбум тог, хувь/

	2000		2001		2002		2003	
	дүн	%	дүн	%	дүн	%	дүн	%
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	429.7	100	489.7	100	548.6	100	616.5	100
1.Урсгал зардал	314.1	73.1	366.7	74.9	413.5	75.4	446.3	72.4
Бараа үйлчилгээний зарлага	208.5	48.5	254.7	52.0	283.9	51.8	286.9	46.5
Зээлийн үйлчилгээний зарлага	18.2	4.2	16.5	3.4	19.6	3.6	33.6	5.5
Татаас ба урсгал шилжүүлэг	87.4	20.3	95.5	19.5	109.9	20.0	125.8	20.4
2.Хөрөнгийн зардал	52.6	12.2	59.1	12.1	68.1	12.4	88.8	14.4
3.Дотоод, гадаад зээлийн үндсэн төлбөр	63.0	14.7	63.9	13	67.1	12.2	81.43	13.2

	2004		2005		2006	
	дүн	%	дүн	%	дүн	%
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	752.5	100	764.6	100	1046.5	100
1. Урсгал зардал	538.7	71.6	600.3	78.5	795.3	76.0
Бараа үйлчилгээний зарлага	356.2	66.4	386.7	64.4	506.7	63.7
Зээлийн үйлчилгээний зарлага	22.1	4.1	20.1	3.3	20.2	2.5
Татаас ба урсгал шилжүүлэг	160.4	29.8	192.9	32.1	268.3	33.7
2. Хөрөнгийн зардал	104.9	13.9	89.8	11.7	177.6	17.0
3. Дотоод, гадаад зээлийн үндсэн төлбөр	108.9	14.5	74.5	9.7	73.6	7.0

Эх сурвалж: Тухайн жилүүдийн статистикийн эмхтгэл, СЯ-ны мэдээнд тулгуурлан тооцов

Төсвийн нийт зарлага энэ хугацаанд 2.4, урсгал зарлага 2.5, хөрөнгийн зардал 3.4 дахин нэмэгджээ. Хөрөнгө оруулалтад зориулсан хөрөнгө илүү хурдтай өсжээ.

2000-2006 онд төвлөрсөн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гадаад дотоод зээлийн үндсэн төлбөр нэмэгдэж байгаатай уялдаж урсгал зарлагын бүтцэд өөрчлөлт орсон байна.

2003 оноос “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай” шинэ хууль эхлэн хэрэгжиж нэг ёсондоо төсвийн шинэчлэлийн хоёрдахь шатны арга хэмжээ авагдав. Төсвийн зарлагын зарцуулалтанд салбарын яамд өөрөөр хэлбэл төсвийн ерөнхий эрх захирагчдын үүрэг өндөржиж, зарлагын менежментийн агуулга өөрчлөгдөж байна. Үүнтэй уялдаж төсвийн зарлагын зориулалтын ангилалд нэлээд өөрчлөлт орлоо.

Хүснэгт 7.

Төсвийн зарлагын зориулалтын бүтэц /тэрбум төгрөг, %/

	2000		2001		2002	
	дүн	%	дүн	%	дүн	%
Нийт зардал	429.7	100	489.7	100	548.6	100
Үүнээс: Нийтийн ерөнхий үйлчилгээ	42.2	9.8	50.4	10.3	54.0	9.8
Боловсролын үйл ажиллагаа	82.1	19.1	98.7	20.2	103.7	18.9
Эрүүл мэндийн үйл ажиллагаа	46.0	10.7	53.1	10.8	58.0	10.7
Нийгмийн даатгал, нийгмийн халамж	76.0	17.7	84.5	17.3	96.0	17.7
Орон сууц нийтийн аж ахуйн	7.0	1.6	7.1	1.4	7.6	1.4
Амралт спорт соёл урлаг	14.3	3.3	15.1	3.1	17.5	3.2
Эрчим хүч дулаан хангамж	8.6	2.0	11.2	2.3	15.0	2.7
ХАА ойн аж ахуй	8.3	1.9	11.7	2.4	13.8	2.5
Эрдэс баялаг уул уурхайн үйлдвэр барилга	1.6	0.4	2.1	0.4	3.8	0.7

Тээвэр холбоо	8.9	2.1	13.3	2.7	16.2	3.0
Эдийн засгийн бусад	5.6	1.3	6.8	1.4	10.9	1.9
	2003		2004		2005	
	дүн	%	дүн	%	дүн	%
Нийт зардал	616.5	100	752.5	100	764.6	100
Үүнээс: Нийтийн ерөнхий үйлчилгээ	58.4	9.5	90.6	12.0	113.4	14.8
Боловсролын үйл ажиллагаа	120.9	19.6	131.7	17.5	153.8	20.1
Эрүүл мэндийн үйл ажиллагаа	57.6	9.3	71.9	9.6	77.8	10.2
Нийгмийн даатгал, нийгмийн халамж	113.9	18.5	146.7	19.5	184.8	24.2
Орон сууц нийтийн аж ахуйн	7.3	1.2	10.8	1.4	11.1	1.4
Амралт спорт соёл урлаг	17.6	2.9	20.7	2.8	18.3	2.4
Эрчим хүч дулаан хангамж	18.0	2.9	27.8	3.7	20.8	2.7
ХАА ойн аж ахуй	12.9	2.1	12.3	1.6	12.8	1.8
Эрдэс баялаг уул уурхайн үйлдвэр барилга	3.6	0.5	4.0	0.5	4.0	0.5
Тээвэр холбоо	21.3	3.5	17.9	2.4	18.4	2.4
Эдийн засгийн бусад	12.4	2.0	14.3	1.9	14.6	1.9

Эх сурвалж: Тухайн онуудын статистикийн эмхтгэлийн болон СЯ-ны тоо баримтыг

ашиглан тооцов

Төсвийн зарлагын зориулалт өөрчлөгдсөн. 2003 оны байдлаар төсвийн зарлагын 52% нь нийгмийн хүрээнд зориулагдаж байсан бол 2006 онд 58.3% болж нэмэгдсэн байна.

Боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаанд зориулсан санхүүжилтын хэмжээ нэмэгдүүлэх явдал хөгжлийн захиалга болж байна.

Боловсролын салбарын санхүүжилтын хэмжээ 2006 онд 2000 оныхоос 1.9 дахин өсч, төсвийн зарлагад 20.1%-ийг эзлэх болжээ. Мөн эрүүл мэндийн салбарын санхүүжилт 1.7 дахин өсч, 10.2%-ийг эзлэж байна.

Боловсрол, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх талаар төр засгаас тавьж байгаа зорилт, тухайн салбарт хийгдэж буй шинэчлэлтэй холбогдон эдгээрт төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэмжээ цаашид улам нэмэгдэх хандлагатай байна.

Хүн амын өсөлт, бүтэц, нэг өрх ба хүнд ноогдох орлогын түвшингээр Монгол орон нэлээд өвөрмөц бөгөөд одоогийн байдлаар зарим талаар хүндрэх төлөвтэй байгаа юм. Ядуурал, ажилгүйдлийн түвшин харьцангуй өндөр байна.

Хөдөлмөрийн чадваргүй хүмүүс болон ядуу эмзэг хэсгийн тэтгэвэр, тэтгэмж халамжийг нэмэгдүүлэх талаар төр засгаас авч байгаа арга хэмжээний үр дүнд нийгмийн даатгалын болон халамжийн сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээ өсөх төлөвтэй. Энэ нь өнөө үеийн нэн чухал шаардлага юм. Нийгмийн даатгалын сангийн нийт орлого 2006 онд 104.4 тэрбум төгрөг

болж 2000 оныхоос 2.7 дахин өссөн байна. Үүний 80 гаруй хувийг ажил олгогч аж ахуйн нэгжээс ба ажиллагсдаас төлөх шимтгэлээр бүрдүүлж байна. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага 184.8 тэрбум төгрөг болсон нь 2000 оныхоос 2.4 өсчээ. Үүний 90.2%-ийг тэтгэвэрт, 3.4%-ийг тэтгэмжинд зарцуулжээ.

Эдийн засгийн тогтворжилтыг тодорхойлсон макро эдийн засгийн тодорхойлогч үзүүлэлтийн нэг нь төсвийн алдагдал юм. Улсын орлого зарлагын харьцааны зохицуулалттай эдийн засгийн тогтолцоог бүрдүүлж чадсан оронд төсөв алдагдалгүй эсвэл бага алдагдалтай байдаг.

Төсвийн алдагдал эдийн засгийн хөгжил, тэнцвэржилт, зохицолдоонд сөргөөр нөлөөлдөг гаж үзэгдлийн нэг юм. Заавал бага эдийн засагтай хөгжил буурай орнуудын төсөв нь алдагдалтай байна гэсэн ёс байхгүй, үйлдвэржсэн өндөр хөгжилтэй орон ч төсөв алдагдалтай байх цаг үе тохиолдоно.

Манай орны төсвийн алдагдал гарахад янз бүрийн шалтгаан нөлөөлж байв.

- Эдийн засгийн хямрал удаан үргэлжлэх;
- Татвар төлөгч аж ахуйн нэгжүүд санхүүгийн доройтолд орох;
- Зайлшгүй шаардлагаар зарлагын эрэлт хэрэгцээ ихсэх, ялангуяа хөрөнгө оруулалтын санхүүжилт нэмэгдэх;
- Үйлдвэрлэлийн бус, зориулалтын биш үр ашиггүй зарлага хэт ихсэх;
- Нийгмийн болон байгалийн гэнэтийн гаж үзэгдэл /дайн түрэмгийлэл, газар хөдлөл, гал түймэр, халдварт өвчин тархах/ гарз хохирол, сүйрлийн аюул тохиолдох;
- Улс орны харилцаа холбоо бүхий гадаад эдийн засаг, улс төрийн харилцаанд сөрөг нөлөөлөл бүхий зохисгүй өөрчлөлт гарах зэрэг болно.

Хүснэгт 8.

Төсвийн алдагдал 1991–1999 он /сая төгрөг/

	1991	1992	1993	1994	1995
Урсгал тэнцэл	1340.5	741.4	10298.7	9964.0	34176.1
Нийт тэнцэл	-2.160	-106.2	-6783.0	-13471.9	-8447.5
Нийт алдагдал ДНБ-д %	-15.1	-4.8	-4.1	-4.2	-1.5
	1996	1997	1998	1999	
Урсгал тэнцэл	26150.9	13413.6	-5643.0	8.9	
Нийт тэнцэл	16643.4	75584.0	116695.8	106896.6	
Нийт алдагдал ДНБ-д %	-2.6	-9.1	-14.3	-11.6	

Төсвийн урсгал тэнцэл 1993 оноос алдагдалгүй болж ашиг нь өсөж байснаа 1996 оноос буурч улмаар 1998 онд 5.6 тэрбум төгрөгийн алдагдалтай болжээ. Нийт төсвийн алдагдал ерөнхийдөө жил дараалан өсөж 1998 онд

116.7 тэрбум, 1999 онд 106.9 тэрбум төгрөгийн алдагдалтай болжээ. Алдагдлын ДНБ-д эзлэх хувь буурч байснаа 1997 оноос өсөж 1998 онд 14.3 хувь, 1999 онд 11.6 хувь болж өсчээ.

2000–2006 онд төсвийн алдагдал туйлын ба харьцангуй хэмжээгээрээ буурах хандлагад орж, харин 2005 оноос төсвийн нийт тэнцэл ашигтай гарах болжээ.

Хүснэгт 9.

2000–2006 оны төсвийн алдагдал /сая төгрөг, %/

	2000	2001	2002	2003
Урсгал тэнцэл	32086.5	63250.6	56281.5	80089.9
Нийт тэнцэл	-78569.4	-50440.5	-71590.2	-80741.2
Алдагдал ДНБ-д эзлэх %	-7.7	-4.5	-5.8	-5.9
	2004	2005	2006	
Урсгал тэнцэл	167593.6	232296.0	408902.6	
Нийт тэнцэл	-39372.8	73261.2	162681.8	
Алдагдал ДНБ-д эзлэх %	-2.1	3.2	5.6	

Төсвийн урсгал тэнцлийн ашиг жилээс жилд өсөх болж, нийт тэнцэл алдагдалтай боловч төлөвлөсөн хэмжээнээсээ жил бүр буурч, ДНБ-д эзлэх хувь нь доошилж байна. 2005 онд төсвийн урсгал тэнцэл 232.3 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл нь 73.2 тэрбум төгрөгийн ашигтай болж, тэр нь ДНБ-д 3.2 хувийг эзэлж байна. Харин 2006 онд урсгал тэнцэл 400 гаруй тэрбум төгрөгийн ашигтай гарав.

Энэ бол манай төсөв санхүүгийн чадавхи сайжирч байгааг тодорхойлно. Төсвийн чадавхийг улам сайжруулж нийт тэнцлийн ашигтай байдлыг бэхжүүлэх нь чухал зорилт мөн.

Зах зээлийн харилцааны гүнзгийрэлт, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн өсөлт, тогтворжилт, цаг үе, орчин нөхцлийн өөрчлөлттэй уялдаатайгаар төсвийн орлого, зарлагын удирдлага, төлөвлөлт татварын тогтолцоо улам боловсронгуй болж байх шаардлагатай.

Манай орны эдийн засаг нийгмийн хөгжилд ахиц гарч, цаашид тогтвортой өсөх нөхцөл бүрдэж байгаа нь санхүү, төсөв, мөнгө, зээлийн тогтолцооны тогтворжилт чадваржилтад ихээхэн нөлөөлж байна. 2002 онд "Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай", "Монгол улсын нэгдсэн төсвийн тухай" шинэ хуулиуд батлагдаж одоо тууштай хэрэгжиж байна. Энэ бол төсвийн шинэчлэлийн чухал үе гэж үзэж болно.

Монгол улсын төвлөрсөн төсөв орон нутгийн төсөв хоорондын харилцаанд зарчмын өөрчлөлт орлоо. Уг шинэчлэлийн зорилго нь:

- Төсвийн төлөвлөлт, санхүүжилт, хяналтыг сайжруулах;
- Богино хугацааны /жилийн/ төлөвлөлтийн тогтолцооноос дунд хугацааны /3 жилийн/ төсөв зохиолтод шилжих;
- Эдийн засаг нийгмийн тэргүүлэх чиглэлийг хөрөнгийн эх үүсвэртэй нягт уялдуулах;
- Төсвийн норм, нормативыг оновчтой болгох;
- Төсвийн байгууллагын ажлын жинхэнэ үр дүн болох бүтээгдэхүүний нийлүүлэлтээр санхүүжилт явуулах төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоог нэвтрүүлэн тайлагналт, хяналтыг сайжруулах.

Цаашид дунд хугацаанд төсөв, татварын шинэчлэлийн талаар баримтлах бодлого нь макро эдийн засгийн тогтворжилт өсөлтийг бататгах, төсвийн тэнцлийг сайжруулах, төрийн үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлж нөөцийг оновчтой хуваарилахад оршиж байгаа юм.

Цаашид анхаарал төвлөрүүлэх хэд хэдэн асуудал:

1. Макро эдийн засгийн дэвшилтэт эергүү хандлагыг хадгалж, улам бэхжүүлэх. Инфляцийг бууруулж, валютын ханшийг тогтвортой байлгах, үндэсний мөнгө-төгрөг бат бөх чадвартай байх нөхцлийг хангах.

2. Эдийн засгийн зохистой бүтцийг бүрдүүлж, оновчтой чиглэлээр хөгжүүлэх нь хэтийн урт хугацаанд тогтвортой байх болно. Үүний тулд шинэ техник, технологид түргэн зохицож, өргөн нэвтрүүлэх эдийн засгийн орчинг бүрдүүлэх. Энэ бол Монголын зах зээлд тэргүүлэх байрыг эзлэнэ.

3. Эдийн засаг, нийгмийг шинэчлэх суурьт хүчин зүйлийн нэг нь улсын санхүү-төсөв болох ёстой. Түүнийг бүрдүүлэх үндэс улс орны урт хугацаанд дэвшингүй хөгжлийг баримтлах ёстой. Санхүү, төсвийн бүх салбар, сүлжээний шинэчлэлд шинжлэх ухааны үүднээс туйлын анхааралтай хандвал зохистой.

Энэ нь эдийн засаг, нийгмийн үр ашигтай бодлогыг бүрдүүлэхэд ихээхэн чухал. Уг бодлого эцэстээ эдийн засгийн өсөлтийн шийдвэрлэх хүчин зүйл болно.

2007 оноос Монгол улсын төсвийн орлогын талд нилээд шинэчлэл хийгдлээ. Шууд ба шууд бус татварын гол төрлүүд болох аж ахуйн нэгжийн орлогын татвар, хүн амын орлогын татвар, НӨАТ, онцгой албан татварын хуулиуд шинэчлэгдэж, татвар ноогдуулах хувь хэмжээг бууруулж, нөхцөл журмыг нь өөрчиллөө.

Санхүү, төсөв, мөнгөний бодлогын үндэслэлийг сайжруулахад дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт, хурдац, түүний хувиарлалтын зохистой харьцааг урт ба богино хугацаагаар төлөвлөх явдал чухал.

Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 15-20 жилийн чиг баримтлалыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсрууллаа. Түүнийг ямар ч төр, засаг

бүрэлдэн тогтсон ч заавал дагаж хэрэгжүүлдэг байх нь олон талын ач холбогдолтой.

Монгол улсын санхүү төсвийн удирдлага, менежментийг улам боловсронгуй болгохын тулд дараах гол зорилтыг тавьж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх дотоод нөөц бололцоог бүрэн дайчлах, хөрөнгийн ашиглалтын үр ашгийг эрс дээшлүүлэх үндсэн дээр санхүүгийн нөөц хангамжийг сайжруулах;

- Санхүү төсвийн чадавхийг нэмэгдүүлж, санхүүгийн нөөцийн дотоод гадаад эх үүсвэрийн зохистой харьцааг тогтоож, дотоод нөөцийг илүү дайчлах зарчмыг баримталж, төрийн өрийн удирдлагыг боловсронгуй болгох;

- Хөрөнгө оруулалтын оновчтой бодлого явуулж, түүний санхүүжилтэд дотоодын эх үүсвэрийг илүүтэй нэмэгдүүлэх явдлыг идэвхижүүлэх, гадаад хөрөнгө оруулалтыг татах;

- Төрийн мөнгөний ухаалаг бодлогыг хэрэгжүүлж, мөнгө зээлийн тогтолцоог улам чадваржуулан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн найдвартай, тогтвортой арга хэрэгсэл болгох;

Татварын хууль, эрх зүйн үндэслэл, удирдлагыг боловсронгуй болгож, тогтолцоог сайжруулах. Ингэхдээ:

- Татварын ачааллыг бууруулах;

- Татварын бааз суурийг өргөтгөх, татвар төлөгчдийн орлого, ашгийг нэмэгдүүлэх, өөрийгөө санхүүжүүлэх нөхцлийг хангах;

- Татвар төлөгчдийг идэвхижүүлэх, урамшуулах аргыг зохистой хослуулж, арга хэлбэрийг боловсронгуй болгох, татвараа зайлшгүй төлөх, тайлагнах ухамсар, идэвхийг татвар төлөгчдөд төлөвшүүлэх;

- Татвар төлөгчдийн санхүүгийн чадварыг дээшлүүлэх үндсэн дээр шууд татвар буюу орлогын албан татварын эзлэх байрыг нэмэгдүүлэх, шууд бус татварын төрөл, ноогдуулах хувь, хэмжээний үндэслэлийг сайжруулах замаар татварын тогтолцооны дотоод бүтцийг шинэчлэх;

- Татвар зохион байгуулалт, хураалт, хяналтын бүхий л үйл ажиллагааг санхүүгийн мэдээллийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх үндсэн дээр явуулах;

- Татварын бодлого, шинэчлэлийн нэг гол зорилт бол далд эдийн засгийг илрүүлэх, түүнтэй тэмцэхэд чиглэгдэх ёстой.

Төсвийн зарлагыг улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийн, нийтлэг зайлшгүй хэрэгцээг хангах хүрэлцээг сайжруулахад чиглүүлж, хөрөнгийн ашиглалтын үр ашиг өгөөжийг дээшлүүлэх. Ингэхдээ:

- Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх төсвийн төвлөрсөн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;

- Хүний хөгжил, ялангуяа боловсрол, эрүүл мэнд, нийгэм хангамж, халамж, ядуурлыг бууруулахад төсвийн хөрөнгийн хуваарилалтыг тогтвортой нэмэгдүүлэх, энэ хүрээнд санхүүжилтийн дотоод, гадаад эх үүсвэрийг зохистой хослох;

- Төсвийн удирдлага санхүүжилтийн шинэчлэлийн өнөөгийн механизмыг улам боловсронгуй болгох;
- Бүс нутгийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан орон нутгийн өөрөө удирдах ёс, бие даах, өөрийгөө санхүүжүүлэх нөхцлийг хангах үүднээс төсвийн орлого, зарлагын өнөөгийн төвлөрлийг өөрчлөх арга хэмжээг авах.

Үүний тулд:

- а) Бүс нутгийн (тодорхой аймаг, хот) эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийг үндэслэлтэй тодорхойлж, үүний дагуу санхүүгийн нөөцийн хэрэгцээг богино ба дунд хугацаагаар төлөвлөх;
- б) Энэ үндсэн дээр төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөх, төсвийн орлогын гол эх үүсвэр бол тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн чанартай аж ахуйн нэгж, хүн амын албан татвар, бусад татвар, хураамж байх болно;
- в) Аймаг, хотын удирдлагын санхүүгийн эрх, үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх замаар орон нутгийн бие даах чадварыг бэхжүүлэх цогц арга хэмжээ авах.

Ийнхүү төсвийн шинэчлэл нь зах зээлийн харилцааны хөгжил, дэвшил, мөнгө санхүүгийн харилцааны шинэчлэлээр нөхцөлдсөн бодит үйл явц бөгөөд энэ утгаараа байнга боловсронгуй болж байх зүй тогтолтой юм.

Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх явдал эдийн засаг, санхүүгийн бодлогын нэн тэргүүний асуудал байна. Хөрөнгө оруулалтын дотоод, гадаад эх үүсвэрийг зохистой хослуулан ашиглах, үр ашгийг дээшлүүлэхэд байнга анхаарна. Хөрөнгө оруулалтын дотоод эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилт тавина.

Гадаадын зээл, тусламжийг шингээх чадвар, төлбөрийн цаашдын даацыг бодолцон хэрэгцээ, чиглэлийг үндэслэлтэй тогтоож, хөрөнгийг зохицуулалт, ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх, гадаад өрийн удирдлагыг сайжруулах явдал байнгын үйл ажиллагаа байх болно.